



АББ-ын энгийн хэрэглээний
ACS580 серийн энергийн хэмнэлттэй
0.75 ~ 250 кВт чадал бүхий
давтамж хувиргагчууд



ACS580 нь АББ-ын шинэ төрлийн, олон талын ажиллагаатай давтамж хувиргагчуудын нэг юм. Энэхүү төхөөрөмжийн онцлог болон авсаархан хийц нь олон төрлийн хэрэглээнд эрчим хүчний хэмнэлт гаргах боломжийг бүрдүүлсэн байна.



Бүхий л төрлийн хэрэглээнд зохицож ажиллах боломжтой шинэ дэвшилтэт технологийн ард ашиглахад хялбар, бүтээжийг нэмэгдүүлж, эрчим хүчийг хэмнэлттэй ашиглахаар зохион бүтээгдсэн АББ-ын давтамж хувиргагч оршдог

Үр ашигтай хийгээд хялбар ажиллагааг хангах нь:

Хананд суурилуулдаг, энгийн хэрэглээний АББ -ын ACS580 серийн давтамж хувиргагчийг төрөл бүрийн үйлдвэрлэлд ашигладаг хувьсах болон тогтмол мушгилтын момент бүхий насос, сэнс, дамжуурга, холигч зэрэг хэрэглээнд өргөнөөр ашигладаг. Мөн уг давтамж хувиргагчийг захиалах, нийлүүлэхэд хялбар бөгөөд угсралт, суурилуулалтад шаардлагатай бүх зүйлсийг оролцуулан нэг дор нийлүүлдэг тул суурилуулалт, ашиглалтын зардал бага байхаар зохион бүтээгдсэн давуу талтай.

Орчин үеийн шинэ технологи ашиглан хийцийг авсаархан, хөнгөхөн, өндөр давтамжийн гармоникүүдыг багасгах болон савлалтын хязгаарлагч технологийг суурилуулж өгсөн нь давтамж хувиргагчийн гол онцлог мөн түүнчлэн цахилгаан соронзон нийцэмжийн (ЦСН) шүүлтүүр, оврын хэмжээ нь R3 хүртэлх давтамж хувиргагч нь тоормозлох хязгаарлагч Modbus fieldbus интерфейс болон мушгилтын моментыг хянаж таслах (STO) тоноглолуудыг агуулдаг. Field bus адаптерын модулиуд нь бүх төрлийн автоматжуулсан системүүдтэй холбогдох боломжийг олгодог.

Удирдлагын дэлгэц дээрх үндсэн тохируулгын цэс болон сайжруулсан тусламжийн цэсүүд нь төхөөрөмжийн суурилуулах хугацааг багасгах боломж олгоно. Уг цэсүүд нь хөдөлгүүр, шууд өсөлт, хязгаарлалтын тохируулгууд гэх мэт функцүүдээр нэрлэгдсэн байдаг. Мөн давтамж хувиргагчийн удирдлагын компьютер дээрх тохируулгын програм нь төхөөрөмжийн хяналт болон процессын тохируулгын өргөн боломж олгодог.

Давтамж хувиргагчийн энергийн оновчтой удирдлагын горим нь нэгж гүйдэл дэх хамгийн их мушгилтын момент болон тэжээлийн үүсгүүрээс хэрэглэж буй энергийн бууруулалтыг хангадаг. Эрчим хүчний хэмнэлтийн тооцоологч нь ашигласан болон хэмнэсэн чадал (кВт/цаг), CO₂ бууруулалт, хэмнэсэн зардал зэргийг оруулан хэрэглэгчдэд оновчтой энергийн зарцуулалт бүхий процессын нарийн тохируулга хийхэд тусалдаг.

Нэг удаа сураад, түүнийгээ төрөл бүрийн ашиглалтанд хэрэглэ!

Хэрэв хэрэглэгч нь энгийн хэрэглээний давтамж хувиргагчаас өөр бусад давтамж хувиргагч ашиглах шаардлага гарвал, АББ-ын давтамж хувиргагчууд нь нийтлэг бүтэцтэй учир ACS880 зэрэг бусад давтамж хувиргагчуудад маш хялбархан байдлаар шилжих боломжтой юм. Эдгээр давтамж хувиргагчууд нь төхөөрөмжийн нэг интерфейс ашигладаг тул хэрэглэгч өмнө нь ашиглаж байсан ACS580 давтамж хувиргагчийн талаарх мэдээлэл, мэдлэгээ мөн ашиглах боломжтой байдаг.



Техникийн өгөгдөл

Хүчдэл болон чадлын түвшин	3-фаз, 200 ~ 240 В эсвэл 380 ~ 480 В, +10/-15% 0.75 ~ 250 кВт хүртэл
Давтамж	50/60 Гц ±5%
Үндсэн хязгаарлагч	Стандартаар, хоёрдугаар үеийн савлалтын хязгаарлагч суурилуулсан
Хамгаалалтын зэрэг	Стандарт - IP21, сонголтын хувилбар - IP55
Хэвийн ажиллах орчин	-15 ~ +50 °C, хөлдөлтөд тэсвэргүй +50 °C -д R0 ~ R3 хүртэл, +40 °C -д R4 ~ R9 хүртэл, +40 ~ +50 °C -д R4 ~ R9 хүртэл, 4000 метр хүртэл 1 °C тутамд 1% гажилттай
Нийцэмж	Европийн холбооны стандартаар баталгаажуулсан (CE)
Аюулгүй ажиллагаа	Мушгилтын моментыг хянах функц (STO) - EN/IEC 61800-5-2, SIL 3, PL e -ийн дагуу
ЦСН	ЦСН заалтын дагуу 2004/108/EC, EN 61800-3:2004 + A1 2012. Стандартын дагуу C2 ангилал
Гармоник бууруулалт	EN 61000-3-12: 2011 -ийн дагуу
Удирдлагын холболтууд	2 аналог оролт, 2 аналог гаралт, 6 тоон гаралт, 3 релений гаралт, EIA-485 Modbus RTU, Мушгилтын моментыг хянах функц (STO), USB порт удирдлагын дэлгэцээр

Удирдлагын болон мэдээлэл дамжуулалтын сонголтууд

Fieldbus адаптерууд	PROFIBUS DP, CANopen [®] , DeviceNet [™] , EtherNet/IP [™] , Modbus TCP, PROFINET IO, EtherCAT [®] , PowerLink, ControlNet
Олон-үйлдэлт өргөтгөлүүд	CMOD-01, хоёр релений гаралт, нэг тоон гаралт, гадны тэжээлийн үүсгүүр +24 В AC/DC CMOD-02, гальваник тусгаарлагдсан PTC оролт, гадны тэжээлийн үүсгүүр +24 В AC/DC
Оролт/гаралтын өргөтгөлүүд	CHDI-01, зургаан 115/230 В AC тоон оролт болон хоёр релений гаралт
Компьютерын програм	Drive composer tool entry - ABB компанийн цахим хуудасаар хандан үнэгүй авах боломжтой. Drive composer tool pro
Удирдлагын дэлгэцний сонголтууд	ACS-AP-S, туслах хяналтын самбар (стандартаар) ACS-AP-I, туслах хяналтын самбар (ACS880 давтамж хувиргагчт мөн тохирно)

Илүү дэлгэрэнгүй мэдээллийг АББ-ын төлөөлөгчийн газар болон дараах цахим хуудас руу хандан авна уу:
www.abb.com/drives
www.abb.com/drivespartners